



## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44,  
Засгийн газрын III байр, Утас: 32 14 33,  
Факс: (976-11) 32 14 33, E-mail: international@nso.mn,  
Website: www.nso.mn

2017. 12.06 № 01/1106  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

Монгол Улсын Хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг 2020 онд зохион байгуулж явуулахтай холбогдуулан “Статистикийн тухай” хуулийн 7.1-ийн а, Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийн 8.2, 13.2 дахь хэсгүүдийг үндэслэн 2020 оны Хүн ам, орон сууцны тооллогын тов тогтоо тухай болон тооллогын Улсын комиссыг байгуулах тухай тогтоолын төслийг тус тус боловсруулж өргөн мэдүүлж байна.

Зохих журмын дагуу Улсын Их Хуралд оруулж, хэлэлцүүлж өгөхийг Танаас хүсье.

Таныг хүндэтгэсэн,

ДАРГА

А.АРИУНЗАЯА

0001661

## ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Хүн ам, орон сууцны  
2020 оны тооллогын тов тогтоо болон  
Улсын комиссыг байгуулах тухай

Монгол Улс хүн амын XX зууны анхны тооллогоо 1918 онд явуулснаас хойш 1935, 1944, 1956, 1963, 1969, 1979, 1989, 2000 онуудад, XXI зуун гарсаар анхныхаа ээлжит тооллогыг 2010 онд, Хүн ам, орон сууцны анхны завсрын тооллогыг 2015 онд зохион байгуулаад байна. Тооллогыг зохион байгуулахдаа мэдээллийн чанар, хүрээг нэмэгдүүлэх, хөрөнгө санхүү болон хүн хүч хэмнэх, тооллогын үр дүнг богино хугацаанд гаргах үүднээс шинэлэг технологи болоод аргачлалыг НҮБ-аас улс орнуудад зөвлөмж болгон боловсруулан гаргасан “Хүн ам, орон сууцны тооллого явуулахад дагаж мөрдөх үндсэн зарчим, арга зүйн зөвлөмж” гарын авлагын аргачлал, арга зүйг мөрдлөг болгон нэвтрүүлж, амжилттай ажилласаар ирсэн. Тухайлбал, гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа иргэдээ тоолох, тооллогын асуулгыг интернетээр нөхүүлэх, газар зүйн мэдээлэлд тургуурласан үр дүн боловсруулах, мэдээлэл цуглувалалтын бүртгэлд сууриссан аргыг нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг сүүлийн тооллогуудын хүрээнд хийгээд байна.

Тооллогын дүнд үндэслэн хүн амын нөхөн үйлдвэрлэлээс хамааралтай нийгмийн хэрэгцээ, түүнийг хангахад чиглэгдсэн эдийн засгийн нөөц боломжийг бүрдүүлэх, хөгжлийн бодлогыг харилцан уялдаатайгаар авч үзэх, хүний нөөцийн бүрдэлт, ашиглалт, ажиллах хүчний хэрэгцээ, хүн амын үндны болон бохир усны төвлөрсөн сүлжээ, боловсрол, нийгмийн халамж үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн хэмжээ, орон сууц, эмнэлэг, сургууль, зам, тээвэр, харилцаа холбоо зэрэг бүхий л салбарын ирээдүйн эрэлт, хэрэгцээг тооцож, бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх үндсийг бүрдүүлэх ач холбогдол бүхий хүн амын хэтийн тооцоо болон тусгайлсан сэдэвчилсэн судалгаануудыг боловсруулан, хэрэглэгчдэд тархаагаад байна.

Хүн ам, орон сууцны тооллого бол хүн ам зүй, нийгэм, эдийн засаг, орон сууцны нөхцлийн талаарх суурь мэдээллийг агуулсан үр дүнг нь нутаг дэвсгэрийн хамгийн

бага нэгж, түүнээс ч нарийвчилсан түвшинд гаргах боломжтой цорын ганц мэдээллийн эх үүсвэр юм. Тооллого зохион байгуулж явуулах нь төрийн бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний оролцоо болон хөрөнгө, хүн хүч шаардсан улсын хэмжээний хамгийн том компанийт ажил байдаг. Тиймээс манай улс тус үйл ажиллагааг Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн заалт болон тусгайлсан хууль болох “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн дагуу зохион байгуулдаг.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7.1-ийн а-д “Хүн амын орон сууцны ээлжит тооллогыг 10 жил тутам, завсрын тооллогыг 5 жил тутам”, “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 8.1-д “Ээлжит тооллогыг 2010 оноос эхлэн 10 жил тутамд нэг удаа улсын хэмжээнд явуулна.”, мөн хуулийн 8.2-д “Тооллогын товыг ээлжит тооллого явуулах хугацаанаас хоёроос доошгүй жилийн өмнө Улсын Их Хурал зарлана.” гэсэн заалтуудын хэрэгжилтийг хангах үүднээс ээлжит тооллогыг 2020 онд зохион байгуулах ба тооллого явуулах тов тогтоох болон тооллогын улсын комисс байгуулах Улсын Их Хурлын тогтоолыг 2017 онд багтаан гаргах шаардлагатай юм.

## ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ТӨСӨЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

.... оны .... сарын .... өдөр

Дугаар ....

Төрийн ордон, Улаанбаатар хот

### **Улсын комисс байгуулах тухай**

Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах Улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

#### **Комиссын дарга:**

Монгол Улсын Ерөнхий сайд

#### **Комиссын орлогч дарга:**

Үндэсний Статистикийн хорооны дарга  
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

#### **Улсын комиссын гишүүд:**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд  
Батлан хамгаалахын сайд  
Гадаад харилцааны сайд  
Сангийн сайд  
Хууль зүй, дотоод хэргийн сайд  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд  
Барилга, хот байгуулалтын сайд  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд  
Зам, тээврийн хөгжлийн сайд  
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд  
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд  
Эрчим хүчний сайд  
Эрүүл мэндийн сайд  
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

#### **Нарийн бичгийн дарга:**

“Хүн ам, орон сууцны тооллогын тухай” Монгол Улсын хуулийн 13.4-т заасан шаардлагыг хангасан орон тооны албан хаагч

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

## **ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ТУХАЙ ХУУЛЬ**

### **13 дугаар зүйл. Ээлжит тооллого зохион байгуулж явуулах байгууллага, түүний эрх хэмжээ**

13.2.Улсын Их Хурал ээлжит тооллого явуулах хугацаанаас хоёроос доошгүй жилийн өмнө Улсын комиссыг Үндэсний статистикийн хорооны санал болгосноор дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

13.4.Энэ хуулийн 13.2-т заасан Улсын комиссын нарийн бичгийн дарга нь дараахь шаардлагыг хангасан байна:

- 13.4.1.төрийн албанад 3-аас доошгүй жил ажилласан;
- 13.4.2.гадаад хэлний зохих мэдлэгтэй;
- 13.4.3.эдийн засгийн дээд боловсролтой;
- 13.4.4.Монгол Улсын иргэн.

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

..... оны .... сарын .... өдөр

Дугаар ....

Төрийн ордон, Улаанбаатар

**Тооллогын тов тогтоох тухай**

Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллогын товыг 2020 оны 1 дүгээр сарын 8-наас 9-нд шилжих шөнийн “00” /тэг тэг/ цагаар тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

## **ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ТУХАЙ ХУУЛЬ**

### **8 дугаар зүйл. Ээлжит тооллогын хугацаа, хамрах хүрээ**

8.2. Тооллогын товыг ээлжит тооллого явуулах хугацаанаас хоёроос доошгүй жилийн өмнө Улсын Их Хурал зарлана.